

PTP Guidelines for Reading Skills in Mongolian

Reading skills in this guideline are defined by the level of the individual's ability to read written texts for the purpose of getting gist, specific information, detailed understanding, and implications.

Novice: this level is characterized by an ability to understand short (50-150 words) simple sentences on familiar matters containing highly frequent words and syntax. The common text sources are from menus, brochures, public notices, and regulations.

Novice 1

- The reader is able to recognize the symbols
- The reader is able to read the words/phrases with slow pace and has difficulty pronouncing less frequent or more than two syllable words.
- The reader can understand only high-frequency vocabulary and short sentence structures.
- The reader has a very general knowledge of administrative division of the country.

Example 1. About myself

Миний тухай

Намайг Буд гэдэг. Би 30 настай. Би монгол хүн. Би нэг жилийн өмнө Америк улсад ирсэн. Би кино үзэх дуртай. Манай аавыг Одон гэдэг. Аав маань инженер. Харин манай ээжийг Энхээ гэдэг. Манай аав, ээж хоёр Улаанбаатар хотод амьдардаг. Би англи хэлний багш. Би оюутнуудтай ажиллах их дуртай. Өнөөдөр Баасан гараг. Би ажил дээрээ ажиллаж байна. Өнөөдөр нартай, дулаан өдөр байна. Манай өрөө халуун байна. Миний ширээн дээр нэг ном, хоёр дэвтэр, хоёр харандаа байна.

Example 2. A letter to a friend

Сайн байна уу, найз аа!

Сонин сайхан юу байна? Сайхан хаваржиж байна уу? Би энэ жил Америкт сурч байна. Би англи хэлний хоёр хичээлд сурч байгаа. Манай багш нарыг Майкл, Дэвид гэдэг. Тэд нар маш сайн багш нар. Одоо би ангидаа сууж байна. Манай анги хоёрдугаар давхарт байдаг. Ангид таван оюутан байна. Нэг оюутан самбар дээр юм бичиж байна. Манай багш ирээгүй байна. Гадаа өнөөдөр дулаахан байна. Гэвч ангид жаахан хүйтэн байна.

За захиа бичээрэй. Баяртай!

2015 оны 3-р сарын 20, Баасан гараг.

Буд

Novice 2.

- The reader is able to read the whole passage with close to normal pace with less pause.
- The reader can recognize only frequently used words and structures
- The reader can get very general main idea of a passage
- The reader can guess the meaning of unknown vocabulary from within a context with low accuracy.

Example 1. Apartment rent ad.

Төмөр замд 3 өрөө бүрэн тавилгатай байр түрээслүүлнэ

Баянгол Дүүргийн Төмөр замд 2011 онд ашиглалтанд орсон 3 өрөө, бүрэн тавилгатай Univision орсон, 2 тагттай, хувцасны өрөөтэй, саруулхан, байршил сайтай 88м² байр урт хугацаагаар түрээслүүлнэ.

Дүүрэг	Баянгол дүүрэг
Байршил	Төмөр зам
Нийт талбайн хэмжээ (м.кв)	88
Ашиглалтанд орсон он	2011
Хэдэн давхар барилга	6
Хэдэн давхарт	4
Цонхны тоо	5
Цонх	Вакум
Хаалга	Төмөр
Шал	Паркет
Гараж	Байхгүй
Сарын түрээс	1.100.000₮

Example 2. TV program**Телевизийн хөтөлбөр**

15.00 “60 секунд” ТВ шоу

16.00 Кофе юу? Цай юу? ярилцлага

17.00 “Ярилцъя” нэвтрүүлэг

18.00 Мэдээ

18.10 Спортын Мэдээ

18.30 “Шагналын Эзэн” уран сайхны кино

20.00 “Цагийн Хүрд” мэдээллийн хөтөлбөр

Intermediate: This level is characterized by the reader’s ability to understand factual information and main ideas from a relatively short passage (150-250 words) that consists of several paragraphs. The texts at this level could be found from the following materials: advertising materials, business and personal letters, abstract, newspaper, and magazines.

Intermediate 1.

- The reader is able to recognize and understand some well-known geographical names of Mongolia.
- The reader can recognize less phonetically affected loan words from English and/or Russian with repeated reading.
- The reader is able to understand culture related contexts with assistance.
- The reader can understand main idea along with guessing more detailed parts of the text

Example 1. Tour Program

ХӨВСГӨЛ ДАЛАЙГ ЗОРИХ ХАМГИЙН ХЯМД, ТУСГАЙ ХӨТӨЛБӨРТЭЙ АЯЛАЛД
НЭГДЭЭРЭЙ

ХАНГАЙ ТУР-2014

эх орноороо аялаж, амрах сайхан боломж

Эх орныхоо үзэсгэлэнт газруудаар аялан амралтаа үр дүнтэй сайхан өнгөрөөхийг хүсэж буй та бүхнийг тусгай хөтөлбөр бүхий сонирхолтой, хөгжилтэй, адал явдалтай, бүтээмч аялалд нэгдэхийг урьж байна. Бүтээмч, танин мэдэхүй, шинэ содон зүйлсээр дүүрэн зугаатай дурсамжтай 2.500 км-ийг хамтгаа өнгөрөөцгөө.

Бүртгэл: 2014 оны 8-р сарын 6-ныг хүртэл

АЯЛАЛЫН МАРШРУТ: Улаанбаатар – Дархан – Амарбаясгалант хийд – Орхоны гүүр – Эрээнэт – Хялганат – Булган – Уран тогоо – Хутаг-Өнцөр – Эг Сэлэнгийн бэлчир – Тариалан – Тосонцэнгэл – Морон – Хатгал – Хөвсгөл далай – Тариат – Тэрхийн цагаан нуур – Хорго – Их Тамир – Өгий нуур – Төвхөний хийд – Улаан цутгалангийн хүрхрээ – Хархорин – Эрээнэ зуу – Элсэн тасархай – Хөгнө хан – Дашинчилэн – Баяннуур – Хустайн нуруу – Улаанбаатар

Өдөр бүр аялалын шинэ хөтөлбөр
 Өртөө бүр сюрприз, шинэ содон зүйлс
 Өндөр зохион байгуулалт, аюулгүй байдал
 Чанартай, баталгаат хүнс, монгол хоол
 Спортын уралдаан, хөгжилтэй тэмцээн, адал явдлууд
 Усан - Морин - Дугуйн - Явган аялалын дэд маршрутууд
 Мэргэжлийн DJ, хотын хөгжим, beach party, cocteil show
 Шинэ газар, шинэ танил, шинэ танин мэдэхүй
 Аялагч бүрт дурсгалын гэрэл зургийн цомог, DVD
 Хөгжилтэй, мэдлэгтэй хөтөч, тайлбарлагчид

*Та зөвхөн аялагчдаа бэлд
 Тусдыг нь бид ...*

АЯЛАЛД НЭГДЭХ

☎ 9011-4404, 9999-9217


✉ khangaitour2014@gmail.com

f Хангай тур - 2014

Example 2. Weather Forecast

Монгол орны болон Улаанбаатар хотын цаг агаарын гурав хоногийн урьдчилсан мэдээ

Маргааш буюу 2015 оны 3-р сарын 25-ны Лхагва гарагт Улаанбаатар хотод багавтар үүлтэй, цас орохгүй. Салхи



баруун өмнөөс 4-9 м/с салхилж, 17 цагт 12 градус, харин 20 цагт 8 градус тус тус дулаан байна.

15 цагт Улаанбаатарт 12 градус дулаан, харьцангуй чийгшил 11 хувь, агаарын даралт 869 гектопаскаль байлаа. Даралт оройдоо тогтвортой байна. Ирэх өдрүүдэд Улаанбаатар хотод хүйтний эрч суларна. Гэвч Монгол орны ихэнх нутгар хүйтэрч, бага зэргийн цас орно. Зүүн аймгуудын нутгаар бороо орно. Хөдөө явахаар төлөвлөж байгаа хүмүүст дулаан хувцасаа авч, машин тэргийнхээ аюулгүй байдлыг хангахыг зөвлөж байна. Харин баруун аймгийн малчдад хүчтэй цасан шуургын үеэр малаа салхи, шуурганд уруудахаас болгоомжилно уу.

Intermediate 2.

- The reader can read the text with normal pace, with almost no pause.
- The reader is able to recognize frequently used loan words that are phonetically unrecognizable in an original language.
- The reader can understand main ideas of longer paragraphs with compound and complex sentences such as adjective and noun clauses.
- The reader can connect and infer the message from the passage with the cultural knowledge he/she is already familiar with.
- The reader can guess unknown vocabulary or phrases easily within contextualized text.
- The reader can comprehend supporting details of a contextualized text.

Example 1. At the market

“Нарантуул” зах дээр

- Сайн байна уу, за дээлнүүд өнгө, загвар, хэмжээгээрээ янз бүр байна шүү. Өмсөөд үзээрэй хө.

- Сайн сайн байна уу, за дээлнүүд ямар үнэтэй байна вэ?

- Янз янзын үнэтэй байна даа. Та яг ямар дээл сонирхож байна вэ?

- Энэ хөх дээл хэд вэ?

- Зуун мянган төгрөг. Та өмсөөд үзээрэй. Яг таарна даа.

- За тэгье.

....

- Ханцуй нь жаахан өргөдөж байна, бас хормой нь арай уртдаж байна.

- Харин тийм байна. Уг нь цээжээрээ яг таарч байх юм. За тэгвэл тэр ягаан дээлийг өмсөөд үзэх үү?

- За тэгье.

- За ямар байна?

- Энэ яг таарч байна. Та үнээ жаахан доошоо ярих уу?

- За наян мянгад шууд ав. Тэрнээс доошоо байхгүй.

- За болж байна. Өөр энэ дээлэнд тохирох бүс, хантааз байна уу?

- Өө, байна байна. Өнгө өнгөөрөө янз янз байна. Та таалагдсанаа шууд аваад өмсөөд үзээрэй.

- За баярлалаа.

- За нийт зуун тавин мянган төгрөг болсон байна. Ингэхэд та хаанахын хүн бэ?



- Аан, би Америк хүн. Монголд аялахаар ирсэн. Тэгээд монгол дээл авах санаатай явна даа.
- Тийм үү, та монголоор ямар сайн ярьдаг юм бэ. Монгол хэл хаана сураа вэ?
- Баярлалаа. Би Индианагийн их сургуульд сурч байхдаа монгол хэл сурсан.
- Та Монголд хэр удах вэ? Хөдөө явах уу?
- Би Монголд гурван долоо хононо. Эхлээд Наадам үзнэ дээ. Тэгээд дараа нь хөдөөгүүр аялах санаатай. Бас боломж олдвол монгол найзуудтайгаа уулзана гэж төлөвлөж байна.
- Мөн мөн. За та сайхан наадаарай. Надаас дээл худалдаж авсанд баярлалаа.
- За та ч бас сайхан наадаарай.



Example 2. Tips and Warning for visitors for 'Naadam' Festival

Наадам үзэхэд анхаарах зүйлс болон зарим зөвлөгөө:

- Наадмын нээлтийн үеэр төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна дотно талаар хөл хөдөлгөөн ихэсч, зам талбай машинаар дүүрдэг тул нээлт эхлэхээс дор хаяж 1.30 минутын өмнө жуулчдаа аван зочид буудлаас хөдлөх хэрэгтэй.
- Хөл хөдөлгөөн маш их тул өөрийн гар утас, зургийн аппарат, түрийвч, мөнгө зэрэг эд зүйлсээ халаасны хулгайчдад алдахаас болгоомжилж, сонор сэрэмжтэй байгаарай.
- Наадмын нээлт үзсэний дараа бөхийн нэгийн давааг эхлүүлээд сурын талбай руу явах хэрэгтэй боловч цаг хожихын үүднээс хажуу талын асарт өрнөж буй “шагайн харваа”-г үзүүлээд, дараа нь нум сумны харвааг үзүүлэх нь тохиромжтой байдаг.
- Наадмын талбайд жил бүр Nomadic expeditions компани “түр ресторан”ажиллуулдаг тул жуулчдаа тэнд ваучераар хооллох боломжтой.
- Наадмын нээлтийн тасалбарыг Нийслэлийн аялал жуулчлалын газар, Хотын захирагчийн албаны "баяр наадмын комисс"-оос худалдан авч болно.
- Өдрийн хоолны дараа хурдан морины талбай руу хөдлөх хэрэгтэй бөгөөд морины талбайд суух суудал ховор, хүмүүс болон морьдын хөлөөр тоос босдог, уралдааны морьд барианд орж ирэх, гараанаас гарах цаг зарим тохиолдолд зөрдөг гэдгийг жуулчиддаа урьдчилан анхааруулж хэлэх хэрэгтэй.
- Оройн цагаар Чингисийн талбай дээр урлагийн тоглолт болон бусад сонирхолтой үйл ажиллагаа болдог тул ирж үзэж сонирхож болно.
- Хот ерөнхийдөө хөл хөдөлгөөн ихтэй болдог учраас хүмүүс Наадмын баярын өдрүүдээр болон оройн цагаар хотын төв гудамжаар алхаж, зугаалах, баар, рестораны газраар орж, үйлчлүүлэх их дуртай байдаг. Та ч бас туршаад үзээрэй.
- Хэрэв боломжтой бол хотын наадам үзэхээс гадна хөдөөний наадам үзэх маш сонирхолтой байдаг тул та хөдөө явах боломж байгаа эсэхийг судалж, төлөвлөж болно.

- Наадмын өдрүүдэд ихэвчлэн нартай, халуун байхаас гадна бороо ордог тул шүхэрээ авахаа мартуузай.

Та бүхэн сайхан наадаарай!

Advanced: This level is characterized by the reader's ability to understand explicit and implicit meanings of a wide range of long (250 words above) and complex texts consisting of several paragraphs.

Advanced 1.

- The reader can identify the hierarchical level of information (i.e., the main points and relevant supporting details) from multi-paragraph prose presented with a clear underlying structure.
- Insufficient target-language cultural knowledge or limited vocabulary may still interfere with complete understanding of a text.
- The reader is comfortable with reading and understanding cultural information from a text.
- The reader can distinguish between formal and informal texts.

Example 1. The leader of Mongolian Democratic Revolution Zorig. S

Монголын ардчилсан хувьсгалын удирдагч С. Зориг

1990 оны Монголын ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг Монголын ардчиллын бэлгэ тэмдэг С. Зориг нь 1962 оны 4-р сарын 20-нд Улаанбаатар хотод төржээ. Түүний аав Санжаасүрэн нь Монголын хүүхэд, залуусын боловсролын төлөө зүтгэж явсан хүн. Ээж



Доржпалам нь Оросын нэрт эрдэмтэн Симуковын охин байжээ. Тэрээр 1960-аад онд гарсан Монголын уран сайхны *Сэрэлт* киноны орос эмчийн дүрд амжилттай тоглож, олны танил болсон юм.

С. Зориг багадаа энгийн даруу, хичээлдээ сайн хүүхэд байжээ. Тэр 10 жилийн 23-р дунд сургуулийг төгсөөд Москвагийн Их Сургуульд орж суралцан, багш болсон юм. Тэрээр 1990 оны ардчилсан хувьсгал эхлэхээс өмнө Монгол Улсын Их Сургуульд багшилж байлаа. 1989 оны 12-р сарын 10-нд Олон Улсын Хүний Эрхийн Өдрөөр Сүхбаатарын талбайд ардчиллын анхны цуглаан болоход индэр дээр туранхай шар залуу гарч, үг хэлсэн юм. Тэр бол ирээдүйн хувьсгалын удирдагч С. Зориг байлаа. Түүний төлөв даруу зан, өндөр мэдлэг, ухаалаг үгс нь ардчилсан хувьсгалын үйл хэрэгт олон

арван залуусыг татан оруулсан юм.

С. Зориг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр гурван удаа сонгогдож байлаа. С. Зоригийн хувьд хүмүүсийн тусын тулд ажиллаж, амьдрах нь хамгийн чухал байсан юм. Түүнд эд мөнгө, хувийн жаргал цэнгэл чухал биш байв. Улс төрийн зүтгэлтэн маань 1998 оны 10-р сарын 2-нд цэл залуу 36 насандаа амь насаа харамсалтайгаар алдсан юм. Түүнийг нас барсны дараа Зориг Сан төрийн бус байгууллага байгуулагдсан ба энэ сан нь түүний алагдсан өдрийг Хүчирхийллийн Эсрэг Өдөр болгон зарласан юм.

Улаанбаатарын төв хэсэгт Монголын Ардчилсан Намын байрны хажууд С. Зоригийн хөшөө байдаг. Энэ хөшөө Монголын ард түмний хандив хөрөнгөөр боссон аж.

Example 2. Mongolian folklore ‘Sisters’

Монгол ардын үлгэр “Эгч дүү”

Эрт урьд цагт уулын энгэрт гурван охинтой, таван хар ямаатай өвгөн эмгэн хоёр аж төрөн амьдарч байсан гэнэ.

Өвгөн өдөр бүр таван хар ямаагаа усны тунгалаг өвсний соргогоор хариулан явдаг байжээ.



Нэг өдөр гэнэт зүү өмнө зүгээс нэгэн шар нохой харвасан сум мэт гүйж ирээд өвгөний таван хар ямааг хазаж майлуулаад сүйд болсонд өвгөн их сандарч шилбүүр эргүүлэн цохилон оржээ.

Өнөөх шар нохой өвгөний зүг ноцон ирсэнд сандарсан өвгөн шилбүүрээ алдан татагдан ойчоод, “амь авраачээ” гэж хашхирсанд нөгөө шар нохой хүний хэлээр “**өвгөн та амьд** явъя гэвэл гурван охиныхоо нэгийг нь надад өг, үгүй бол би чамайг таван хар ямаатай чинь хамт барьж иднэ” гэжээ. Айсан өвгөн алхсаар гэртээ харьж эмгэндээ энэ явдлыг ярьжээ. Тэгээд эмгэн нь том охиноо дуудаад “нэг шар нохой та гурвын нэг аваачихгүй бол аавыг чинь таван хар ямаатай нь иднэ гэнэ.

Охин минь чи очих уу” гэж асуусанд том охин нь

”хүний охин хүнд мордохоос биш юу гэж нохойд мордож байхав дээ, би тэр муу нохойтой чинь суухгүй гэж хаалга саван гарч оджээ. Эмгэн дунд охиноо дуудаж асуусанд мөн л эгчтэйгээ адилхан хариу өгчээ. Хамгийн сүүлд бага охиноо дуудаж асуусанд бага охин нь “бид ааваа идүүлэхгүй, аавынхаа төлөө бид тэр нохойтой сууя” гэжээ. Аав ээж хоёр нь отгон охиноо тэврэн уйлж, нүүр гарыг нь угаагаад шар нохойн дэргэд дагуулж аваачсанд шар нохой юу ч хэлэлгүй отгон охиныг нь нуруун дээрээ унуулмагц наран жаргах зүгт тоос манаруулан одсон гэнэ.

Нэг сар өнгөрөөд өвгөн охиныхоо үхсэн амьдыг нь мэдье гээд хөгшнөөрөө сарын хүнс бэлтгүүлээд хулсан таяг чирч баруун хойд зүг алхжээ. Нэг сар яваад нэг том нүхний дэргэд ирэхэд охиных нь хоёр гутал үзэгджээ. Өвгөн шаналан уйлаад охиныхоо ясыг ч гэсэн авч харья гээд тэр нүх руу оржээ. Өвгөн тэмтчин бүдэрч гурван хоног явсны дараа гэнэт шар гэрэл цацарч сайхан сайхан орд харшууд харагдав гэнэ. Өвгөн гуай энэ бүхнийг мэлрэн гайхаж явсаар яг дэргэд нь хүрч очиход оосор бүчгүй өндгөн цагаан гэрт охин нь гэзгээ самнан сууж байв гэнэ. Уул нь нөгөө шар нохой бол лусын хааны хүү байж, үнэнч шударга хатантай больё гээд шар нохойд хувилан өвгөний бага охинтой суусан юм гэнэ.

Тэгээд хүргэн нь хадам аавдаа мөргөн золгож, адуу мал алт мөнгө бэлэглэн хөгшин буурал аавыгаа хүндэлж, бас юу хүссэн бүхнийг биелүүлж өгдөг эрдэнийн хул бэлэглэсэн гэдэг юм. Сайн санааны үзүүрт сүү гэдэг энэ дээ.

Advanced 2.

- The reader can understand not only the main and supporting ideas, but also can infer the meaning of a text.
- The reader can recognize the author's implication within a context.
- The reader is familiar with frequently used phrases, jargons and idioms in a text.
- The reader can read any longer paragraphs with various types of clauses.
- The reader is comfortable with any geographical and proper nouns and culturally related words and phrases.
- The reader is able to do the different types of reading techniques such as skim and scanning to get the main idea of the text as effectively and quickly as possible.

Example 1. Summary of Mongolian opera 'Three Fateful Hills'

Д. Нацагдоржийн “Учиртай Гурван Толгой” дуурь

Нэгдүгээр үзэгдэл: Хөдөө тал. Үдэш орой болж эх хүний бүүвэйн дуу уянгална. Сэтгэлт хос Юндэн Нансалмаа хоёр уулзаж, бие биедээ хайр сэтгэлээ илэрхийллээ. Юндэн хуримандаа бэлдэхээр хот явна. Өглөө эрт нутгийн эрчүүд Юндэнг гаргаж өгөхөөр цугларав. Юндэнд дурласан нутгийн бүсгүй Хоролмаа ирж Нансалмааг хараад атаархаж, ямар нэгэн хорон муу зүйлийг бодож байлаа. Ямар ч ан агнаж чадаагүй Балган ууртай явж байхад Хоролмаа түүнд Нансалмаа гэдэг сайхан бүсгүйн тухай хэлж, эхнэрээ болгохыг зөвлөв. Ингээд Балган Нансалмааг хүчээр булаан авлаа.

Хоёрдугаар үзэгдэл: Балганы өргөө. Баян Балганы гэрт Нансалмаа эрх чөлөөгүй байлаа. Балган ноён ирж Нансалмааг эхнэрээ болохыг гуйхад бүсгүй хутгыг нь сэм авч, амиа хорлохыг оролдох боловч чадсангүй.

Гуравдугаар үзэгдэл: Юндэнгийн нутгийн зах. Балганы хоёр зарц Юндэнг цохиж унагаад зугтав. Энэ үед Хоролмаа Юндэнг гэртээ оруулж "Минийх боллоо!" хэмээн баярлав. Тэр Юндэнд хайртай бүсгүй нь ноёны хатан болсон гэж хэлээд Юндэнд хайр сэтгэлээ илэрхийллээ.



Дөрөвдүгээр үзэгдэл: Балган ноёны хашаа. Балган Нансалмаатай хүчээр хуримаа хийхийг оролдоно. Юндэн Нансалмааг сэм орлуулахаар шийдэв. Харин Хоролмаа энэ тухай Балганд хэлж Юндэнг шоронд хийлгэж, Юндэнг өөртэйгөө суухыг гуйлаа.

Тавдугаар үзэгдэл: Хөдөө тал. Юндэн нутгийн ардуудтай хамт харгис Балгантай тэмцэхээр шийджээ. Ноёны дарлалд зовсон ардууд тэмцэж, ялав. Хоролмаа жаргах замд нь саад болсон Нансалмааг алах гэсэн боловч Юндэн хайртай бүсгүйгээ аварч чадав. Хайрт Нансалмаагаа харгис ноёны гараас аварч чадсан Юндэн хотол олныг урьж, хурим найраа хийж, аз жаргалтай төгсөнө.



Example 2. Mongolian national festival ‘Naadam’

"Монгол төрийн их наадам"

Монголчууд жил бүрийн 7-р сард “Наадам” тэмдэглэдэг. 1206 оны Улаан барс жил Их монгол улсыг тунхаглаж, Тэмүжинг Чингис хаанд өргөмжилснөөс эхлэн эрийн гурван наадам буюу төрийн их ёслол, баяр наадам хийдэг уламжлал тогтсон байна. 1634 он буюу Лигдэн хутагт хааныг хүртэл 37 хаан эрийн гурван наадмыг төр ёсны их баяр болгон тэмдэглэж байжээ. 16-17-р зууны үед шарын шашин дэлгэрэн уул овоо тахих болсон үед Эрийн гурван наадам хийх болсон байна. 1639 онд Өвөрхангай аймагт Түшээт хан Гомбодоржийн 5 настай хүү Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөн наадам хийжээ. Энэ нь хожмоо **Даншиг наадам** хэмээн алдаршсан билээ. Ардын хувьсгал ялснаас хойш нэг жилийн дараа 1922 онд Буянт-Ухаад улсын чанартай наадмыг анх хийжээ. Үүнийг түүхэнд **Цэргийн наадам** гэж тэмдэглэсэн. Тэр цагаас хойш Ардын хувьсгалын ойн баяр наадам болгон жил бүр тэмдэглэж иржээ. 2003 оны 6 дугаар сард УИХ “Үндэсний их баяр наадмын тухай хуул”-ийг баталжээ. Эдүгээ үндэсний их баяр наадам нь улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмаас бүрддэг. Өөрөөр хэлбэл, сум болгон, аймаг болгон, хот болгон нэгэн зэрэг тэмдэглэдэгээрээ онцлог юм. Улаанбаатарчууд Төв цэнгэлдэх хүрээлэнд хоёр өдрийн турш баяр наадмаа тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ үеэр хүчит бөхчүүдийн барилдаанаас гадна эрхий мэргэн харваачдын наадаан, эрэмгий хурдан хүлэг морьдоо унасан хүүхэдтэй нь баясан харж

бахдахаас гадна үндэсний хувцасны жинхэнэ өнгө алагласан гайхамшигийг таашаан үздэг билээ.

Бөхийн барилдаан: Монголчуудын үндэсний баяр наадмын нэгэн томоохон хэсэг нь бөхийн барилдаан юм. 512 хүчтэн цагт баригдахгүйгээр уудам талбайд барилддаг. Монголчууд эртнээс хүч чадлыг эрхэмлэж ирсэн бөгөөд монгол эрэгтэй хүүхэд болгон багаасаа барилдаж өсдөг. Баяр наадмын өдрүүдэд Улаанбаатарын төв цэнгэлдэх хүрээлэнд 100-гаас илүү жинтэй, тэгш сайхан биетэй, идэр залуу хүч бяртай монгол эрчүүдийг нэгэн дор харна гэдэг бас л нэгэн бахдал гайхамшиг юм.

Сурын харваа: Монгол цэргийн түүхийн оргил нэгэн хэсэг бол яах аргагүй нум сум юм. XIII зууны үед гэр бүрт морин хуураас гадна нум сум байсан. Эр хүн бүр нумтай байхаас гадна эмэгтэй хүн ч гэсэн харвадаг байжээ. Монгол цэргийн түүхэнд хамгийн хол харвасан хүн бол Чингис хааны ач хүү Есүнгэний харвасан 330 алд газар буюу ойролцоогоор 520 метр юм. Чингис хааны цэргийн хамаг хүч чадал нь агт морьд байснаас гадна цэргүүдийнх нь нум сум харвах чадвар байсан гэдгийг дэлхийн судлаачид аль хэдийнээ хүлээн зөвшөөрсөн билээ. Морины давхиан дунд чөлөөтэй эргэж байгаа онож харваж чаддаг байжээ.

Хурдан морины уралдаан: Улаанбаатарт 6 насны ангилалд дунджаар 400 морь буюу хоёр өдөрт 2400 морь уралддаг. Аймгийн төвүүдийн морин уралдааныг оролцуулаад нэгэн зэрэг 26 мянган морьд уралддагаараа гайхалтай. Эцсийн хүчээ шавхах хүртлээ 20-30 километр уралддаг онцлогтой морин уралдаан дэлхийд хаана ч байхгүй. Уяа сойлгыг нь буруу тааруулбал 10 километр ч давхиж чадахгүй, уяа сойлго нь зөв байвал 40, 50 километр байсан ч давхиад барианд орж ирж чадна. 100-500 морьд нэгэн зэрэг уралддаг онцлог нь гадаадын жуулчдад гайхалтай сонин санагдана. Уяачид адуун дотроосоо хурдан удамтай хүлгийг сонгон жилийн дөрвөн улиралд унаж хөнгөрүүлэн байж наадам болохоос сарын өмнөөс уяа сойлгонд жигдлэн оруулж өвс усыг нь тохируулдаг.